



ХИЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ БҮС НУТГИЙН ТӨСӨЛ

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл: МОН-3387

Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг Монгол улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдөр соёрхон баталсан.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл-Нэмэлт санхүүжилт: МОН-3810

Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл-Нэмэлт санхүүжилт”-ийн зээлийн хэлэлцээрийг Монгол улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр 2019 оны 10 дугаар сарын 2-ны өдөр соёрхон баталсан.

Санхүүжүүлэгч байгууллага: Азийн Хөгжлийн Банк

Төсөл, арга хэмжээний зорилго: Хилийн үйлчилгээг сайжруулах замаар гадаад худалдааг хөнгөвчлөх, бараа эргэлтийг нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлэх, худалдаа эрхлэхэд зарцуулах зардлыг бууруулах, цаг хугацаа хэмнэхэд оршино.

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яа

Гүйцэтгэгч байгууллага: Гаалийн ерөнхий газар

Санхүүжилтийн эх үүсвэр (гадаад, дотоод): АХБ-ны санхүүжилт - 27.0 сая ам.доллар; Монголын талын шууд бус санхүүжилт (татварын хөнгөлөлт, чөлөөлөлт) – 2.07 сая ам.доллар Нэмэлт санхүүжилт - 27.0 сая ам.доллар

Төслийн үр шим хүртэгчид:

- Гаалийн хяналт шалгалт хийх, барааг эзэнд нь олгох шийдвэр гаргах Засгийн газрын агентлагууд
- Хилийн менежментийн ажиллагааг гүйцэтгэгч төрийн албан хаагчид
- Олон улсын худалдаа, тээврийн үйлчилгээнд хамаарах худалдаа эрхлэгчид, тээвэр зуучийн байгууллагууд, гаалийн зуучлагчид
- Гадаад худалдаанаас хамааралтай салбарын бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчид, малчид, тариаланчид
- Гадаад худалдаа зах зээлд нэвтрэх боломжоос хамааралтай хилийн боомтуудын ойр оршин суугчид

Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд: MON-3387

- Бүрэлдэхүүн хэсэг 1: Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг, Сүхбаатар хилийн боомтын барилга байгууламжийн ажил
 - Алтанбулаг хилийн боомтод зорчигч тээврийн 19, ачаа тээврийн 18, дэд бүтцийн 5 барилга, иж бүрэн инженерийн шугам, сүлжээ, 6000м² ногоон байгууламж, тусгаарлах зурвас бүхий 4 эгнээ 1.7км авто зам, 7000м² авто зогсоол, 30000м² зам талбайн барилга угсралтын ажил
 - Сүхбаатар хилийн боомтод Хилийн хяналтын байгууллагуудын Нэг цэгийн үйлчилгээний цогцолборын /3600м²/ барилга угсралтын ажил
 - Алтанбулаг, Бичигт хилийн боомтуудын гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн шинэчлэлт
- Бүрэлдэхүүн хэсэг 2: Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийн өргөтгөл
 - Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийг /КАИС/-ийг өргөтгөл, цахим нэг цонхны системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлт
 - Гаалийн байгууллагын Дата төвийн сервер, компьютер тоног төхөөрөмжийн шинэчлэлт
 - Гаалийн байгууллагын Мэдээллийн технологийн сүлжээний өргөтгөл
- Бүрэлдэхүүн 3: Гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх 1-р үе шатын ажил
 - Гадаад худалдааны цахим нэг цонхны талаарх сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулах
 - Гадаад худалдааны цахим нэг цонхны програм хангамжийг боловсруулах, бүс нутгийн түвшинд мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх
 - Цахим нэг цонхны системд шаардагдах сервер, компьютер тоног төхөөрөмжөөр бүрэн хангах

Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд: MON-3810

- Бүрэлдэхүүн хэсэг 1: Бичигт, Боршоо хилийн боомтын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг сайжруулах, өргөтгөх, шинэчлэх
- Бүрэлдэхүүн хэсэг 2: Чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (хил дээр хяналт хэрэгжүүлдэг холбогдох байгууллагуудад зориулсан сургалтууд үүнд хамаарна)

1. АЛТАНБУЛАГ ХИЛИЙН БООМТ

Алтанбулаг Боомтод Зорчигч тээврийн 19, ачаа тээврийн 18, дэд бүтцийн 5 барилга, иж бүрэн инженерийн шугам сүлжээ, 6000 м2 ногоон байгууламж, Зорчигч тээврийн цогцолборт хүлээлгийн болон үйлчилгээний танхимуудыг цогцоор нь байгуулж, зорчигчдын ая тухтай орчинг бий болгоно. Тус боомтод тусгаарлах зурвас бүхий 4 эгнээ 1,7 км урттай авто зам, 7000 м2 авто зогсоол, 30000 м2 боомтын доторх зам талбай, зорчигч, тээврийн хэрэгслийг түргэн шуурхай нэвтрүүлэх, орчин үеийн технологи бүхий гарцуудыг шинээр ашиглалтад оруулна.

Цар тахлаас өмнөх үеийн байдлаар “Алтанбулаг” боомтын хилийн шалган нэвтрүүлэх цэгээр өдөрт дунджаар 1000-1100 хүн, 50-60 тээврийн хэрэгсэл нэвтэрч байсан.

Энэхүү бүтээн байгуулалтын үр дүнд Алтанбулаг боомтоор өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 3 дахин ачааны тээврийн хэрэгслийн тоо 4 дахин нэмэгдэж иргэд аж ахуй нэгжүүдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх боломж нөхцөл бүрдэж улмаар гадаад худалдааны эргэлт мөн хэмжээгээр нэмэгдэнэ.

1.1. АЛТАНБУЛАГ ХИЛИЙН БООМТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛИЙН АЖИЛ

АЛТАНБУЛАГ ХИЛИЙН БООМТЫН ШИНЭЧИЛСЭН ТӨЛӨВЛӨЛТ



1.2. АЛТАНБУЛАГ ХИЛИЙН БООМТЫН АВТО ЗАМ, АВТО ЗОГСООЛЫН АЖИЛ

АВТО ЗАМ, АВТО ЗОГСООЛЫН ХАРАГДАХ БАЙДАЛ



2. СҮХБААТАР ХИЛИЙН БООМТ

Хил дээр хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын үйлчилгээг хүртээмжтэй, ил тод, үр ашигтай хүргэх механизмыг бий болгох зорилгоор Сүхбаатар боомтод нэг цэгийн үйлчилгээний цогцолборыг барихаар төлөвлөсөн. Ингэснээр зорчигчид болон гадаад худалдаа эрхлэгчдийн төмөр замын боомт дээр зарцуулж буй цаг хугацаа, зардлыг 30-иас доошгүй хувиар бууруулж улмаар боомтоор түргэн шуурхай нэвтрэх боломж бүрдэнэ.

СҮХБААТАР ХИЛИЙН БООМТЫН НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР



3. БОРШОО ХИЛИЙН БООМТ

Хилийн боомтын барилга байгууламжийг шинэчлэн сайжруулж өргөтгөх замаар зорчигч, тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэхэд зарцуулах цаг хугацааг багасгаснаар худалдаа хөнгөвчлөгдөж, гадаад худалдааны эргэлт нэмэгдэнэ.

Цар талхаас өмнөх үеийн байдлаар “Боршоо” боомтын хилийн шалган нэвтрүүлэх цэгээр өдөрт дунджаар 200-235 хүн, 50-60 тээврийн хэрэгсэл нэвтэрч байсан.

Энэхүү бүтээн байгуулалтын үр дүнд Боршоо боомтоор өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4.8 дахин ачааны тээврийн хэрэгслийн тоо 3 дахин нэмэгдэж иргэд аж ахуй нэгжүүдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх боломж нөхцөл бүрдэж улмаар гадаад худалдааны эргэлт мөн хэмжээгээр нэмэгдэнэ.

3.1. БОРШОО БООМТЫН АВТО ЗАМ, ГАДНА ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ УГСРАЛТЫН АЖИЛ



3.2. БОРШОО БООМТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН УГСРАЛТЫН АЖИЛ



4. БИЧИГТ ХИЛИЙН БООМТ

Бичигт хилийн боомтын одоо байгаа хяналтын бүсийг хойд зүгт 2,3 км-т 14 га талбайд шилжүүлэх байдлаар эх загвар зургийг боловсруулж, Бичигт боомтод баригдах 2.5 км орчим 4 эгнээ авто замыг БНХАУ-ын Зүүн хатавчийн хилийн боомтын автозамын төлөвлөлттэй уялдуулна.

Бичигт боомтод зорчигч тээврийн 24 барилга байгууламж, дэд бүтэц, ногоон байгууламж баригдана. Түүнчлэн шуурхай удирдлагын төвтэй холбогдсон орчин үеийн теле хяналтын

систем бүхий тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх ухаалаг гарцууд болон өндөр хүчин чадлын рентген, тоног төхөөрөмжүүд суурилагдана.

Цар тахлын өмнөх үеийн байдлаар “Бичигт” боомтын хилийн шалган нэвтрүүлэх цэгээр өдөрт дунджаар 250-300 хүн, 120-150 тээврийн хэрэгсэл нэвтэрч байсан.

Боомтын шинэчлэлээр өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4 дахин, ачааны автомашины тоо 3 дахин нэмэгдэж зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэн, ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

БИЧИГТ ХИЛИЙН БООМТЫН ШИНЭЧИЛСЭН ТӨЛӨВЛӨЛТ



ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ

“Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хууль <https://www.legalinfo.mn/law/details/11957>

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн зээлийн хэлэлцээр <https://www.adb.org/sites/default/files/project-document/183863/47174-001-sfj.pdf>

Төсөл хэрэгжүүлэхэд баримтлах гарын авлага <https://www.adb.org/sites/default/files/project-documents/47174/47174-001-pam-en.pdf>

Төслийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө <https://www.adb.org/sites/default/files/project-documents/47174/47174-001-pp-en.pdf>

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн-Нэмэлт санхүүжилтийн зээлийн хэлэлцээр <https://www.adb.org/sites/default/files/project-documents/47174/47174-002-lna-en.pdf>

Төсөл хэрэгжүүлэхэд баримтлах гарын авлага <https://www.adb.org/sites/default/files/project-documents/47174/47174-002-pam-en.pdf>

Төслийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

<https://www.adb.org/sites/default/files/project-documents/47174/47174-002-pp-en.pdf>

ТАЙЛАНГУУД

<https://www.adb.org/projects/47174-001/main>

ХОЛБОО БАРИХ

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-3 Бодь цамхаг 10 давхар 1004 тоот, Улаанбаатар хот 15160, Монгол Улс

Утас: 976-75553387

Цахим шуудан: procurement.ribs@gmail.com